

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орж ажилласнаар та дараах баталгаагаар хангагдана.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн цалин хөлс нь:

Үндсэн цалин, Цолны нэмэгдэл, Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, Төрийн тусгай алба хаасан хугацааны болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ. Ажилласан жил нэмэгдэх тусам цалин өснө

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчид дүрэмт хувцсаар хангах, эсхүл мөнгөн хангамжийг олгоно.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцах тохиолдолд тухайн алба хаагчийн суралцах хугацааны цалин болон ирэх буцах тээврийн зардлыг төрөөс хариуцна.

Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 жил ажиллаж байгаа цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг олгоно.

Мөн аймгийн төвөөс бусад суманд томилогдсон цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангана.

Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралтын хугацаа 15 хоног байх бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчийн ажилласан 2 жил тутамд 3 хоног, бусад чиг үүрэгтэй алба хаагчийн ажилласан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралтыг олгоно.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.

Ингэснээр та Цагдаа, дотоод цэргийн байгууллагад тасралтгүй 20 буюу түүнээс дээш жил ажилласан тохиолдолд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгож болно.

Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоход 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 1 удаа олгоно.